



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 06 сарын 12 өдөр

Дугаар A/418

Арвайхээр

### Тендерийн гүйцэтгэгчийг сонгох, тендер хүчингүй болгон дахин зарлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үнэлгээний хорооны 2019 оны 6 дугаар сарын 12-ний өдрийн 60 дугаар зөвлөмжийн дагуу улсын төсвийн хөрөнгөөр санхүүжих Боловсрол, соёл, спортын салбарын их засвар, тоног төхөөрөмж /Өвөрхангай/ ажлын гүйцэтгэгч болон нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийн Багц-1 Цэцэрлэгийн барилгын дээврийн засвар / Өвөрхангай, Бүрд сум/ багцыг 24982050 (хорин дөрвөн сая есөн зуун наян хоёр мянга тавь) төгрөгөөр Девсофт ХХК-иар, Багц-2 Сургуулийн 80 хүүхдийн дотуур байрны барилгын их засвар /Өвөрхангай, Баян-Өндөр/ багцыг 74894469 (далан дөрвөн сая найман зуун ерэн дөрвөн мянга дөрвөн зуун жаран ес) төгрөгөөр Дуутын нуруу ХХК-иар, Багц-3 Цэцэрлэгийн барилгын их засвар /Өвөрхангай, Баян-Өндөр/ багцыг 59899062 (тавин есөн сая найман зуун ерэн есөн мянга жаран хоёр) төгрөгөөр Дуутын нуруу ХХК-иар, Багц-4 Сургуулийн дотуур байрны гал тогооны барилгын их засвар /Өвөрхангай, Баянгол/ багцыг 110458618 (нэг зуун арван сая дөрвөн зуун тавин найман мянга зургаан зуун арван найм) төгрөгөөр Бэлчирконстракшн ХХК-иар, Багц-5 Ерөнхий боловсролын сургуулийн барилгын сантехникийн их засвар /Өвөрхангай, Төгрөг сум/ багцыг 48900000 (дөчин найман сая есөн зуун мянга) төгрөгөөр Идум ХХК-иар, Багц-6 Соёлын төвийн барилгын их засвар /Өвөрхангай, Төгрөг сум/ багцыг 49940389 (дөчин есөн сая есөн зуун дөчин мянга гурван зуун наян ес) төгрөгөөр Чусан ХХК-иар, Багц-7 Цэцэрлэгийн барилгын их засвар /Өвөрхангай, Гучин-Ус сум/ багцыг 48451112 (дөчин найман сая дөрвөн зуун тавин нэгэн мянга нэг зуун арван хоёр) төгрөгөөр Өвтана ХХК, Багц-9 Сургуулийн 100 хүүхдийн дотуур байрны их засвар /Өвөрхангай, Богд сум/ багцыг 73297351 (далан гурван сая хоёр зуун ерэн долоон мянга гурван зуун тавин нэг) төгрөгөөр Эрчхүч хөгжил ХХК-иар, Багц-10 Соёлын төвийн барилгын их засвар /Өвөрхангай, Богд сум/ багцыг 50000000 (тавин сая) төгрөгөөр Эрчхүч хөгжил ХХК-иар, Багц-11 Ерөнхий боловсролын сургуулийн гадна фасад, их засвар /Өвөрхангай, Баруунбаян-Улаан сум/ багцыг 57000000 (тавин долоон сая) төгрөгөөр Эрхэс-Импэкс ХХК-иар, Багц-12 Соёлын төвийн барилгын их засвар /Өвөрхангай, Нарийнтээл/ багцыг 35000000 (гучин таван сая) төгрөгөөр Тэд констракшн ХХК-иар, Багц-14 Цэцэрлэгийн барилгын сантехникийн засвар /Өвөрхангай, Өлзийт сум/ багцыг 80965419 (наян сая есөн зуун жаран таван мянга дөрвөн зуун арван ес) төгрөгөөр Хасдөл ХХК-иар, Багц-15 Цэцэрлэгийн барилгын их засвар /Өвөрхангай, Есөнзүйл сум/ багцыг 79509785 (далан есөн сая таван зуун есөн мянга долоон зуун наян тав) төгрөгөөр Девсофт

011100695

ХХК-иар, Багц-16 Соёлын төвийн барилгын дээврийн засвар/ Өвөрхангай, Есөнзүйл сум/ багцыг 14537045 (арван дөрвөн сая таван зуун гучин долоон мянга дөчин тав) төгрөгөөр Ганцаг ХХК-иар, Багц-17 Сумдын соёлын төвүүдийн техник, тоног төхөөрөмж /Өвөрхангай, 8 сум/ багцыг 63840000 (жаран гурван сая найман зуун дөчин мянга) төгрөгөөр Тэрэмбаян ХХК-иар тус тус гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Гэрээ байгуулан, ажлын явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээж авахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Г.Баясгалан)-т даалгасугай.

3. Дээрх шалгарсан багцуудад гэрээнд заасан хуваарь, гүйцэтгэлийн дагуу санхүүжилт олгохыг аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газар (Н.Ганболд)-т даалгасугай.

4. Нэг ч оролцогч үнийн санал ирүүлээгүй багц-8 Ерөнхий боловсролын сургуулийн барилгын их засвар /Өвөрхангай, Гучин-Ус сум/, багц-13 Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны их засвар /Өвөрхангай, Хайрхандулаан сум/, багц-18 нэгдүгээр цэцэрлэгийн агааржуулалт засвар /Өвөрхангай, Богд сум/ багцуудыг хүчингүй болгосугай.

5. Дээрх хүчингүй болсон багцуудыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалтын дагуу хязгаарлагдамал тендер шалгаруулалтаар цахимаар дахин зохион байгуулахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газар (Н.Ганболд)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД